



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 15/01

Арвайхээр сум

Г Хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн Г  
хэрэгжилтийн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03/10 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төсөлд тавигдах шаардлага, тогтоолын биелэлтийг үнэлэх журам”-ын 3.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан хэм хэмжээ тогтоосон 15 шийдвэрийн хэрэгжилтийг 90.0 хувьтай хэрэгжсэн гэж үзсүгэй.

2. Эрх зүйн үндэслэл хүчингүй болсон холбогдох шийдвэрүүдийг 2026 оны 2 дугаар улиралд багтаан шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагын шийдвэрээр баталгаажуулан, хэрэгжилт, зохион байгуулалтыг орон нутгийн түвшинд бүрэн хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга О.Пүрэвдоржид даалгасугай.

3. Хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийн хэрэгжилт, үр дүнд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай зохицуулалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Т.НАРАНГАРАВ

622601014